



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Диспетчерийн үндэсний төвийн ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/091/НА-СТА-ТӨАГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Аудитор: Г.Оюунтөгөлдөр
Утас: 261740 Цахим хаяг: ouyntuguldurg@audit.gov.mn
Цэгцтөв богд аудит ХХК-ийн захирал: Н.Цэрэнханд
Утас: 99901517 Цахим хаяг: tsegtstuvbogd@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ Г.БАЛЖИННЯМ
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1059
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Диспетчерийн үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны 11 дүгээр сард хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр төлбөрийн үлдэгдэлтэй хэрэглэгчид нэмэгдэж, шөнийн тарифын хөнгөлөлтийн хугацааг сунгасантай холбоотойгоор түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн орлого төвлөрүүлэлт хангалтгүй, Эрчим хүчний зохицуулах хорооноос 2024 оны 12 сард тарифын зохицуулалт хийснээс төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд худалдах, худалдан авах дундаж тарифыг 190.66 төг/квт.ц байсныг 255.95 төг/квт.ц болгон нэмэгдүүлснээр нэг худалдан авагчтай загварын дансны авлага 29,164.8 сая төгрөг буюу 55.9 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нийлүүлэх эрчим хүчний чадал, энергийн саналыг Эрчим хүчний зохицуулах хороо хянаж, нэг худалдан авагчийн загварын тайланд мөрдөх тариф, мөнгөн урсгалын коэффициентийг тогтоон баталдаг. Тайлант оны нэг худалдан авагчийн болон экспорт, импортын тарифийн 4,566.1 сая төгрөгийн сөрөг зөрүүг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт, өмнөх оны нэг худалдан авагчийн 1,962.1 сая төгрөгийн эерэг зөрүүгээр экспорт, импортын 1,709.6 сая төгрөгийн сөрөг зөрүү хааж,

Z:\Yawsan_Bichig\2025\0317 SNAG-19.Docx

1525070973

тарифийн зохицуулалтын нөөц хөрөнгө буюу бусад эргэлтийн бус хөрөнгийг 4,313.6 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,829,767,708.31	7,079,348,635.76
1.1.02	Дансны авлага	52,201,490,367.94	81,366,307,790.69
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	3,805,211,798.87	6,119,498,374.87
1.1.04	Бусад авлага	10,135,834,893.59	4,636,829.03
1.1.06	Бараа материал	350,773,457.90	386,180,871.34
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,365,465.88	2,624,808.75
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	72,325,443,692.49	94,958,597,310.44
1.2.01	Үндсэн хөрөнгө	10,746,721,490.31	11,750,169,218.21
1.2.02	Биет бус хөрөнгө	1,363,449,121.79	1,710,102,738.29
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	4,313,588,107.07
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,110,170,612.10	17,773,860,063.57
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	84,435,614,304.59	112,732,457,374.01
2.1.1.01	Дансны өглөг	67,100,493,702.66	95,632,823,132.12
2.1.1.03	Татварын өр	894,748,650.55	671,968,985.99
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	676,400,096.66	359,180,150.77
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	139,528,416.37	194,123,547.19
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	68,811,170,866.24	96,858,095,816.07
2.1.2.01	Урт хугацаат зээл	5,913,016,763.68	5,475,015,427.32
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	4,251,011,462.07	1,908,191,199.36
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	150,816,074.27	202,909,051.34
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	10,314,844,300.02	7,586,115,678.02
2.2	Өр төлбөрийн нийт дүн	79,126,015,166.26	104,444,211,494.09
2.3.01	Өмч: - төрийн	1,811,705,231.02	1,811,705,231.02
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	587,815,153.11	1,804,259,515.08
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	140,628,482.55	140,628,482.55
2.3.09	Хуримтлагдсан ашиг	2,769,450,271.65	4,531,652,651.27
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	103,022,465.47
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	2,769,450,271.65	4,428,630,185.80
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,309,599,138.33	8,288,245,879.92
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	84,435,614,304.59	112,732,457,374.01

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,442,518,781,436.96	1,593,236,591,905.71
02	Борлуулалтын өртөг	1,447,600,063,440.57	1,595,468,139,087.43
03	Нийт ашиг(алдагдал)	(5,081,282,003.61)	(2,231,547,181.72)
05	Хүүний орлого	165,936,491.30	362,376,451.35
08	Бусад орлого	9,053,309,055.94	9,009,680,779.48
08.1	Орлогын дүн	9,219,245,547.24	9,372,057,230.83
09	Борлуулалт, маркетингийн зардал	717,139,313.73	840,698,279.89
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,299,754,236.71	2,914,607,699.28
11	Санхүүгийн зардал	126,033,418.02	118,357,973.31
12	Бусад зардал	751,342,136.11	918,825,424.02
12.1	Зардлын дүн	3,894,269,104.57	4,792,489,376.50
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(78,391,937.35)	(2,156,835,414.38)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	136,363.64	416,909.09
17.1	Олз, гарзын дүн	(78,255,573.71)	(2,156,418,505.29)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	165,438,865.35	191,602,167.32
19	Орлогын татварын зардал	17,934,695.82	36,486,724.78
19.1	Хойшлогдсон татварын зардал	39,703,926.12	52,092,977.07
20	Татварын дараах ашиг (алдагдал)	107,800,243.41	103,022,465.47
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	107,800,243.41	103,022,465.47

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	2,701,418,227.80	5,241,567,094.48
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(39,768,199.56)	(39,768,199.56)
3	Залруулсан үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	2,661,650,028.24	5,201,798,894.92
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	107,800,243.41	107,800,243.41
5	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	2,769,450,271.65	5,309,599,138.33
6	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	1,713,080,035.86	1,713,080,035.86
7	Залруулсан үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	4,482,530,307.51	7,022,679,174.19
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	103,022,465.47	103,022,465.47
9	Зарласан ногдол ашиг	-	-	-	(53,900,121.71)	(53,900,121.71)
10	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	1,216,444,361.97	-	-	1,216,444,361.97
11	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,811,705,231.02	1,804,259,515.08	140,628,482.55	4,531,652,651.27	8,288,245,879.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,485,280,723,760.47	1,586,127,531,933.13
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,484,491,529,941.04	1,572,769,146,987.46
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	12,150,900.00	2,179,305.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	777,042,919.43	13,356,205,640.67
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,487,103,902,496.93	1,580,274,419,355.89
1.2.1	Ажиллагчдад төлсөн	5,582,949,454.64	7,497,317,012.98
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,478,076,753.23	1,881,314,272.83
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,438,427,380,319.91	1,534,164,491,254.95
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	639,835,979.02	747,839,878.93
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	100,084,663.38	134,457,671.60
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	126,033,418.02	118,357,973.31
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	30,166,352,638.65	34,789,738,285.59
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	11,257,297.13	14,039,746.38
1.2.9	Бусад мөнгөн зарлага	10,571,931,972.95	926,863,259.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,823,178,736.46)	5,853,112,577.24
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	166,086,491.30	362,485,777.26
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	150,000.00	458,600.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	165,936,491.30	362,027,177.26
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,701,246,069.07	2,799,332,220.87
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,401,208,940.07	2,152,320,894.92
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	300,037,129.00	647,011,325.95
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,535,159,577.77)	(2,436,846,443.61)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,424,346,534.97	4,844,148,174.52
3.1.4	Бусад	3,424,346,534.97	4,844,148,174.52
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,098,589,299.53	7,010,833,380.70
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	438,001,336.18	438,001,336.18
3.2.4	Төлсөн ногдол ашиг	55,662,371.17	53,900,121.71
3.2.5	Бусад	3,604,925,592.18	6,518,931,922.81
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(674,242,764.56)	(2,166,685,206.18)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,032,581,078.79)	1,249,580,927.45
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,862,348,787.10	5,829,767,708.31
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,829,767,708.31	7,079,348,635.76

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар болсон

/сая.төгрөг/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь	
1	Цахилгаан эрчим хүч:	Нийт хэрэглээ /боловсруулалтаар /	сая.кВтц	9,218.4	9,488.9	270.5	102.9
		Боловсруулалт	сая.кВтц	8,291.8	8,331.6	39.8	100.5
		Түгээлтээр	сая.кВтц	7,318.1	7,365.9	47.8	100.7
	Дулааны эрчим хүч:	Боловсруулалт	мян.Гкал	10,881.0	10,792.9	(88.1)	99.2
		Түгээлтээр	мян.Гкал	10,601.5	10,519.6	(81.9)	99.2
2	Нийт орлого		сая.төг	13,554.7	14,121.4	566.7	104.2
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	12,803.9	12,803.9	-	100.0
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	750.8	1,317.5	566.7	175.5
3	Нийт зардал		сая.төг	13,554.6	13,947.9	393.3	102.9
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	13,075.7	13,075.7	-	100.0
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	478.9	872.2	393.3	182.1
	Элэгдлийн зардал		сая.төг	2,037.5	2,086.7	49.2	102.4
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая.төг	0.1	173.4	173.4	
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая.төг	0.1	103.0	103.0	
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1.00	0.99	(0.01)	98.8
7	Нийт авлага		сая.төг	600.0	447.0	(153.0)	74.5
	Үүнээс:	ЭХ-ний	сая.төг	-	-	-	
		бусад	сая.төг	600.0	447.0	(153.0)	74.5
8	Нийт өглөг		сая.төг	8,050.0	7,790.1	(259.9)	96.8
	Үүнээс:	УХӨТ	сая.төг	7,800.0	7,586.1	(213.9)	97.3
		БХӨТ	сая.төг	250.0	204.0	(46.0)	81.6
9	Нийт ажилчдын тоо		тоо	125.0	121.0	(4.0)	96.8
10	Нийт цалингийн сан		сая.төг	7,928.4	7,927.2	(1.1)	100.0
11	Диспетчерийн үр ашигтай зохицуулалт, горим төлөвлөлт		төг	154.76	149.71	(5.0)	96.7
12	Их засвар,ТЗБАХ,Хөрөнгө оруулалт		сая.төг	3,041.5	2,920.2	(121.3)	96.0
	Үүнээс:	Их засвар	сая.төг	79.9	78.8	(1.1)	98.7
		ТЗБАХ	сая.төг	477.7	475.1	(2.6)	99.4
		Хөрөнгө оруулалт	сая.төг	2,483.9	2,366.3	(117.6)	95.3
13	Ногдол ашиг		сая.төг	18.1	51.5	33.4	284.6

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 53.9 сая төгрөгийн 1 алдааг¹ залруулав.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өмчийн өөрчлөлтийн тайланд 2023 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас төлсөн ногдол ашгийн 53.9 сая төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулгад тайлагнасан байна.	1	53,900.1	-	-	1	53,900.1	1	53,900.1	-	-	-	-
Дүн	1	53,900.1	-	-	1	53,900.1	1	53,900.1	-	-	-	-

3.2. Аудитаар нийт 671.8 сая төгрөгийн зөрчлийг² илрүүлж, 671.8 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
"Байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй зардалд автобазаас машин хөлслөн ажиллуулж 28.4 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулжээ.	1	28,400.0	-	-	1	28,400.0	-	-	-	-	-	-
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын өдрийн тоот тогтоол, Эрчим хүчний сайдын 2024 оны А/198 дугаар тушаалаар батлагдсан "компанийн 2024 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин"-ний нийт зардлыг 393.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	1	393,300.0	-	-	1	393,300.0	--		-	-	-	-
2024 оны санхүүгийн тайланд ААНБОАТ-ын авлага 50.0 сая төгрөг, НӨАТ-ын авлага 3,187.9 сая төгрөг нийт 3,237.9 сая төгрөгийг Монголын татварын албаны аж ахуйн нэгж байгууллагын тодорхойлолтой тулган баталгаажуулахад 205.1 сая төгрөгийн зөрүүтэй байна.	1	250,116.1	-	-	1	250,116.1	-	-	-	-	--	-
2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулгыг бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.	1	-	-	-	-	--	1	-	-	-	--	
Дүн	4	671,816.1	-	-	3	671,816.1	1					

3.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2023-2024 оны “хамтын гэрээ”-г Хан-Уул дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс 2023 оны 03 дугаар сарын 24-нд баталгаажуулсан нь хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, урамшуулал, дэмжлэг олгох нөхцлийг бүрдүүлсэн байна.	1	-	--	-	1	-
Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлуулахгүйгээр бүтэц орон тоог өмнөх оноос 5 хүнээр нэмсэн байна	1	-	1	-	-	-
Дүн	2	-	1	-	1	-